



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шилүүстэй сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/45/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 9999-3365 Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn</p> <p>Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч: Г.Заяа Утас: 9203-8288 Цахим хаяг: zayaq@audit.gov.mn</p> <p>Аудитор Г.Чулуунбаатар Утас: 9908-4581 Цахим хаяг: chuluunbaatar@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Төрийн аудитын санал, дүгнэлт



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ШИЛҮҮСТЭЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.ГАНБОЛД-д

2022-02-24 № 1302/200.
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан аймгийн Шилүүстэй сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан аймгийн Шилүүстэй сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

01302/135

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мян.төг/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>113,160.64</u>	<u>78,016.96</u>
33	АВЛАГА	2,112.94	2,087.50
335	Бусад авлага	2,112.94	2,087.50
3351	Байгууллагаас авах авлага	25.44	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,087.50	2,087.50
35	БАРАА МАТЕРИАЛ	111,047.70	75,929.46
354	Хангамжийн материал	38,982.70	39,284.46
35410	Бичиг хэргийн материал	777.67	628.62
35420	Аж ахуйн материал	15,839.38	16,786.88
35430	Сэлбэг хэрэгсэл	415.10	415.10
35440	Түлш, шатах тослох материал	2,359.41	1,312.72
35450	Барилгын засварын материал	707.00	707.00
35470	Бусад хангамжийн материал	18,884.15	19,434.15
35600	Мал амьтад	72,065.00	36,645.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>595,086.51</u>	<u>529,830.15</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	595,086.51	529,830.15
392	Биет хөрөнгө	590,750.01	526,073.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	569,124.18	569,124.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	-82,540.77	-119,940.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	124,970.15	124,970.15
39204	Хуримтлагдсан элэгдэл	-90,251.90	-102,982.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	205,397.31	205,397.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-177,910.34	-184,997.81
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,989.50	66,506.07
39208	Хуримтлагдсан элэгдэл	-35,793.42	-42,276.98
39214	Бусад үндсэн хөрөнгө	36,386.80	32,460.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-25,298.47	-23,863.67
39217	Ном	1,676.96	1,676.96
393	Биет бус хөрөнгө	4,336.50	3,756.50
39301	Програм хангамж	3,055.00	3,055.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-972.50	-1,552.50
39303	Бусад биет бус хөрөнгө	2,254.00	2,254.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>708,247.15</u>	<u>607,847.12</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>708,247.15</u>	<u>607,847.12</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	708,247.15	607,847.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	383,252.13	383,252.13
51101	Өмч: - төрийн	383,252.13	383,252.13
512	Хуримтлагдсан үр дүн	-51,840.24	-152,240.27
51210	Өмнөх үеийн үр дүн	-51,840.24	-51,840.24
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-100,400.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	376,835.26	376,835.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>708,247.15</u>	<u>607,847.12</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мян.төг/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	409,307.24	351,873.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,422.42	6,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	59,422.42	6,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,422.42	6,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	59,422.42	6,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	349,884.82	345,873.45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	347,373.30	324,496.30
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	347,373.30	324,496.30
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,511.52	21,377.15
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,511.52	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,141.97
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	20,235.18
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	402,510.77	450,630.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	402,510.77	450,630.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	380,094.83	428,623.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	226,091.99	209,865.81
210101	Үндсэн цалин	226,091.99	197,889.29
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	11,976.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,109.66	27,037.40
210201	Тэтгэврийн даатгал	19,114.57	18,770.48
210202	Тэтгэмжийн даатгал	2,248.77	2,082.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,799.02	1,666.32
210204	Ажилгүйдлийн даатгал	449.75	411.69
210205	Эрүүл мэндийн даатгал	4,497.54	4,106.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,877.97	16,898.77
210301	Гэрэл, цахилгаан	1,293.97	1,394.16
210302	Түлш, халаалт	10,584.00	15,504.61
2104	Хангамж, бараа материалын зардал	22,082.73	33,883.38
210401	Бичиг хэрэг	1,803.02	2,381.73
210402	Тээвэр, шатахуун	15,842.05	23,412.16
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,241.45	1,619.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,196.21	5,743.10
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	726.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,022.90	1,332.00
210604	Урсгал засвар	3,022.90	1,332.00
2107	Томилолт, зочны зардал	3,115.00	3,288.00
210702	Дотоод албан томилолт	3,115.00	3,288.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,331.70	2,778.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,778.75	1,143.68
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232.00	540.00
210803	Даатгалын үйлчилгээ	20.00	469.10
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	227.70
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	40.80

Шилүүстэй сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	162.65	203.40
210807	Газрын төлбөр	138.30	138.30
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	15.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,462.88	133,539.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,801.00	63,623.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	263.35	303.31
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,398.53	69,613.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,415.95	22,006.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,464.70	13,085.10
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,464.70	13,085.10
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,951.25	8,921.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,951.25	8,921.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	6,796.46	-98,757.04
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,642.99
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,642.99
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,642.99
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	6,796.46	-100,400.04

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	383,252.13	376,835.26	-51,840.24	708,247.15
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	383,252.13	376,835.26	-51,840.24	708,247.15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	383,252.13	376,835.26	-51,840.24	708,247.15
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-100,400.04	-100,400.04
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	383,252.13	376,835.26	-152,240.27	607,847.12

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	349,884.82	345,873.45
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	349,884.82	345,873.45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	347,373.30	324,496.30

Шилүүстэй сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	347,373.30	324,496.30
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,511.52	21,377.15
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,511.52	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,141.97
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	20,235.18
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	337,338.62	345,873.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	337,338.62	345,873.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	314,922.67	323,866.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,252.52	209,838.29
210101	Үндсэн цалин	202,241.43	197,861.77
210105	Гэрээт ажлын хөлс	19,011.10	11,976.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,630.32	27,039.48
210201	Тэтгэврийн даатгал	20,796.81	18,749.36
210202	Тэтгэмжийн даатгал	2,157.12	2,086.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,780.86	1,668.77
210204	Ажилгүйдлийн даатгал	445.27	412.35
210205	Эрүүл мэндийн даатгал	4,450.25	4,122.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,498.61	14,611.86
210301	Гэрэл, цахилгаан	1,795.20	1,451.00
210302	Түлш, халаалт	12,703.41	13,160.86
2104	Хангамж, бараа материалын зардал	15,412.07	23,309.18
210401	Бичиг хэрэг	2,085.80	2,232.68
210402	Тээвэр, шатахуун	11,769.17	19,457.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,557.10	1,619.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,472.00	1,332.00
210602	Тавилга	1,200.00	00.00
210604	Урсгал засвар	1,272.00	1,332.00
2107	Томилолт, зочны зардал	3,115.00	3,288.00
210702	Дотоод албан томилолт	3,115.00	3,288.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,909.65	3,368.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,848.75	2,041.87
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232.00	232.10
210803	Даатгалын үйлчилгээ	20.00	469.10
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.70	227.70
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73.80	40.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	353.40	203.40
210807	Газрын төлбөр	138.30	138.30
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.70	15.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,632.50	41,078.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,329.10	40,775.68
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303.40	303.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,415.95	22,006.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,464.70	13,085.10

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,464.70	13,085.10
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,951.25	8,921.58
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,951.25	8,921.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,546.20	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,546.20	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,546.20	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,546.20	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,546.20	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-13,546.20	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-1,000.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,000.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мян.төг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	373,591.90	343,422.05	338,485.20	317,034.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	373,591.90	343,422.05	338,485.20	317,034.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	355,127.20	324,957.35	325,400.10	303,949.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	230,858.90	222,998.57	222,858.90	209,838.29
210101	Үндсэн цалин	209,762.20	203,987.47	201,762.20	197,861.77
210105	Гэрээт ажлын хөлс	21,096.70	19,011.10	21,096.70	11,976.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,166.10	27,884.27	30,086.10	27,039.48
210201	Тэтгэврийн даатгал	21,931.60	20,649.58	21,171.60	18,749.36
210202	Тэтгэмжийн даатгал	2,308.60	1,783.29	2,228.60	2,086.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,846.90	1,454.20	1,782.90	1,668.77
210204	Ажилгүйдлийн даатгал	461.80	426.30	445.80	412.35
210205	Эрүүл мэндийн даатгал	4,617.20	3,570.90	4,457.20	4,122.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,796.20	14,748.61	14,796.20	14,611.86
210301	Гэрэл, цахилгаан	2,071.20	2,045.20	2,071.20	1,451.00
210302	Түлш, халаалт	12,725.00	12,703.41	12,725.00	13,160.86
2104	Хангамж, бараа материалын зардал	16,311.30	17,708.50	23,309.20	23,309.18
210401	Бичиг хэрэг	2,232.70	2,232.70	2,232.70	2,232.68
210402	Тээвэр, шатахуун	11,436.40	13,436.40	18,434.30	19,457.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,642.20	2,039.40	2,642.20	1,619.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,689.20	8,895.20	1,494.60	1,332.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,799.90	00.00	00.00
210602	Тавилга	3,000.00	4,200.10	00.00	00.00
210604	Урсгал засвар	4,689.20	2,895.20	1,494.60	1,332.00
2107	Томилолт, зочны зардал	5,668.20	2,915.00	3,291.60	3,288.00

Шилүүстэй сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	5,668.20	2,915.00	3,291.60	3,288.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,360.10	10,139.00	2,560.10	2,527.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,200.00	6,979.00	1,200.00	1,199.90
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232.10	232.00	232.10	232.10
210803	Даатгалын үйлчилгээ	469.10	469.10	469.10	469.10
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.70	227.70	227.70	227.70
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73.80	73.80	73.80	40.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,003.40	2,003.40	203.40	203.40
210807	Газрын төлбөр	138.30	138.30	138.30	138.30
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.70	15.70	15.70	15.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,277.20	19,668.20	27,003.40	22,003.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,973.80	19,364.80	26,700.00	21,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303.40	303.40	303.40	303.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,464.70	18,464.70	13,085.10	13,085.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,464.70	18,464.70	13,085.10	13,085.10
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,464.70	18,464.70	13,085.10	13,085.10
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	373,591.90	347,373.30	338,485.20	324,496.30
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	373,591.90	347,373.30	338,485.20	324,496.30
131001	Улсын төсвөөс санхүүжих	373,591.90	347,373.30	338,485.20	324,496.30
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	23.00	22.00	23.00
620001	Удирдах ажилтан	07.00	07.00	07.00	07.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	06.00	05.00	06.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22.00	23.00	22.00	23.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	07.00	07.00	07.00	07.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06.00	06.00	06.00	06.00
650010	Гэрээт ажилтан	03.00	04.00	03.00	04.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	06.00	06.00	06.00	06.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,917.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,917.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,917.65
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	841.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	841.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19075.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,075.68

II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21377.15
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,377.15
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,141.97
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,235.18

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шилүүстэй сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн, аудитор Г.Чулуунбаатар нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Шилүүстэй сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 3/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шилүүстэй сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаа нь “Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж, мэргэшсэн албан хаагчдаар төрийн албыг бэхжүүлэн, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэж, сумын хөгжлийн төлөө ажиллах”-д оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж тус байгууллагад байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шилүүстэй сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 345,873.5 мянган төгрөгийн 2.0 хувь буюу 6,917.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 5,533.97 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	2,112.94	2,087.50	-25.44
Бараа материал	111,047.70	75,929.46	-35,118.24
Үндсэн хөрөнгө	595,086.51	529,830.15	-65,256.36
Нийт хөрөнгө	708,247.15	607,847.12	-100,400.03
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	708,247.15	607,847.12	-100,400.03
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	708,247.15	607,847.12	-100,400.03

Авлагын дансны үлдэгдэл 2,087.5 мянган төгрөг болж буурсан нь он дамжсан авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 75,929.46 мянган төгрөг болж буурсан нь мал амьтад дансанд бүртгэлтэй хонь, ямааг холбогдох малчдад борлуулж Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 529,830.15 мянган төгрөг болж буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 607,847.12 мянган төгрөг болж буурсан нь хуримтлагдсан үр дүн 100,400.03 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дээд шатны төсөв захирагч тус байгууллагын 2021 оны төсвийн зарлагыг 338,485.2 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 338,485.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 317,034.22 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 19,917.65 мянган төгрөгийн, нийт 336,951.87 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 336,951.87 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 19,917.65 мянган төгрөгийн орлого хүлээн авч 100 хувь зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын үйл ажиллагаанд онцолж үзэх асуудал байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын үйл ажиллагааны зардал болох тээвэр шатахуун нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байдлыг санхүүгийн аудитаар шалгахад материаллаг алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс 144 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроон оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд НББ-ийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн тайлагнаж Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт 1, албан шаардлага 2, зөвлөмж 1-ийг тус тус хүргүүлсэн байна. Төлбөрийн акт болон зөвлөмжийн биелэлт 100 хувь, албан шаардлагын биелэлт 85.0 хувьтай хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх материаллаг эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар нийт 52,922.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 47,483.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,701.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,737.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.1 Залруулсан алдаа

Харилцагч байгууллагын төлбөрийн баримтгүй /и-баримт/ ажил гүйлгээ хийсэн /халаалтын төлбөр/ 11,913.2 мянган төгрөг

Бусад биет бус хөрөнгө /газар/-д элэгдэл тооцсон, мал худалдан борлуулсаны орлого ОНХС-д төвлөрүүлсэн байхад санхүүгийн тайланд буурсан бичилтээр тусгаагүй нийт 35,570.3 мянган төгрөг

4.2 Төлбөрийн акт

Улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад /Засаг даргын орлогч, багийн засаг дарга нар/ үр дүнгийн урамшуулал олгосон 880.5 мянган төгрөгийн, 2 ажилтанд ээлжийн амралтын мөнгө илүү тооцож олгосон 821.3 мянган төгрөгийн, нийт 1,701.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй болно.

4.4 Зөвлөмж

Холбогдох эзэн нь тодорхой н.Оргилсайхан, н.Баасанхүү, н.Мөнх-Эрдэнэ, н.Баяртогтох, н.Ойдов, н.Санжсүрэн нартай холбоотой 2012, 2017 онуудад үүссэн 2,087.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулах.

Си-Ти-Эс ХХК-ний 1,650.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн болон няравын программыг 2022 онд ашиглах.

Мал амьтад дансанд бүртгэлтэй хонь, ямааг холбогдох малчдад борлуулж, Орон нутгийн хөгжлийн санд бүрэн төвлөрүүлэх.

Зөвлөмжийн хариуг 2022.10.01-ний өдрийн дотор албан тоотоор ирүүлэх

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шилүүстэй сумын Засаг даргын тамгын газар	7	52,922.8	3	47,483.5	1	1,701.8	-	-	3	3,737.5

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Г.ЧУЛУУНБААТАР

ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ЗАЯА

2022.02.25